



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар

A/10

Хэрлэн сум

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн A/70 дугаар тушаалаар батлагдсан “Танхим ашиглалт”-ын журмын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан иргэний танхим болон сургалтын танхимын төлбөрийг нэг өдрийн 100000 төгрөг, нэг цагийн 30000 төгрөг болгож өөрчлөлт оруулсугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Танхим ашиглалт”-ын журмын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн (Ж.Энхбат)-д, аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР